



БАЯНХОНГОР АЙМАГ САНХҮҮГИЙН  
ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБА  
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН  
АКТ

2024 оны 01 сарын 08 өдөр

Дугаар 09/19-06/08

Номгон

Шинэжинст сумын Засаг даргын Тамгын  
газрын цалин хөлсөд илүү олгосон  
мөнгийг нөхөн төлүүлэх тухай

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, албаны даргын баталсан 07/02 дугаар удирдамжийн дагуу Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10 дахь зүйл, 69 дүгээр зүйлийн 69.3 дахь хэсгийн заалт, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8.2 дахь "Аймаг, нийслэлийн Засаг даргын тусгай бүрэн эрх" 8.2.3 дахь "сум, дүүрэг, харьяа байгууллага, аж ахуйн нэгжийн төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, бүртгэл санхүүгийн үйл ажиллагаанд баримтын шалгалт хийх арга хэмжээ авна", Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан "Дотоод аудитын дүрэм", Сангийн сайдын 2016 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 107 дугаар тушаалаар баталсан "Санхүүгийн хяналт шалгалтын стандарт"-д заасан бүрэн эрхийн хүрээнд Шинэжинст сумын Эхэнхавцгай 4 дүгээр багт байрлах Засаг даргын Тамгын газрын (9009175) 2022, 2023 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч Д.Мөнхханд 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдөр хүртэл хийж гүйцэтгэлээ.

Шалгалтаар: Цалин хөлсөд 2,345,652 төгрөгийг илүү олгосон зөрчил илэрлээ. Үүнд:

1. Шинэжинст сумын Засаг даргын 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн "Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр Гончигжавын Өлзийбатыг томилох тухай" Б/13 дугаар захирамжаар Төрийн албаны нөөцөд байсан хүнээр ЗДТГ-ын даргыг түр орлон гүйцэтгүүлсэн атлаа Дотоод ажил, хууль, эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэний ажлыг давхар хавсран гүйцэтгүүлж, нөөцөд байгаа хүнээр төрийн захиргааны албан тушаалыг зэрэгцүүлэн хашуулж ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл хөлсөд 1,414,241 төгрөгийг олгосон.

2. Шинэжинст сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн "Ш.Бямбацогоод сахилгын арга хэмжээ тооцох" Б/20 дугаар тушаалаар арга хэмжээ авсан байхад үр дүнгийн мөнгөн урамшуулалд 292,611 төгрөгийг олгосон.

3. Санхүүгийн албаны дарга Х.Дагважавт амралтын олговор, цалин хөлсийг давхардуулан 638,800 төгрөгийг цалин хөлсөд илүү олгосон.

Дээрх зөрчил нь Хөдөлмөрийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.3 дахь "гүйцэтгэсэн ажил үүрэгтээ тохирсон цалин хөлс авах", Нийтийн албанд нийтийн болон хувийг ашиг

642409095

сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5 дахь “Энэ хуулийн 18.2-18.4-т зааснаас бусад албан тушаалтан дараах ажлыг давхар эрхэлж болно”, 18.5.1 дэх “хууль тогтоомж, олон улсын гэрээгээр болон Засгийн газраас баталсан журмаар зөвшөөрсөн ажил”, 18.5.2 дахь “багшлах, эрдэм шинжилгээний болон бүтээлч ажил” гэсэн заалт, Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам”-ын 2.3-т “Төрийн албаны тухай хуулийн 43.3.4-т заасан үндэслэлээр төрийн албан хаагчийн нөөцөд бүртгэгдсэн иргэнийг сонгон авч түр орлон гүйцэтгүүлсэн бол тухайн албан тушаалын цалинг түүнд олгоно”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.1-т “Хуульд өөрөөр заагаагүй бол улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолт, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, хөдөлмөрийн гэрээнд заасан ажил, үүргээ хангалттай гүйцэтгэсэн, ажлын байранд хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй албан хаагчид олгоно” гэснийг зөрчсөн.

Монгол Улсын Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12.2-т “аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хууль бусаар олсон орлого, эд хөрөнгийг акт үйлдэж улсын орлого болгох, түүнчлэн бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх” гэсэн заалт, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 7.5-т “Санхүүгийн хяналт шалгалтын улсын (ахлах) байцаагч нь шалгалтаар тогтоосон ажлын үр дүн, зөрчил, түүнийг арилгах талаар цаашид авах арга хэмжээг тодорхойлсон шалгалтын тэмдэглэл, санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж зөрчсөн албан тушаалтны төлөх торгууль, төлбөрийг заасан нэг бүрчилсэн акт, албан шаардлага бичнэ” гэснийг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Цалин хөлсөд илүү олгосон 2,345,652 төгрөгийг холбогдох хүмүүсээр төлүүлэх, эс төлүүлбэл Шинэжинст сумын Засаг даргын Тамгын газрын дарга Л.Батхуяг, Нягтлан бодогч Х.Доржсамбуу нараар хувь тэнцүүлэн төлүүлж, Төрийн сангийн хүү торгуулийн орлогын **100030000982** тоот дансанд (РД:9036001) 2024 оны 08 дугаар сарын 15-ны дотор төвлөрүүлэхийг Шинэжинст сумын Засаг даргын Тамгын газрын дарга Л.Батхуяг, Нягтлан бодогч Х.Доржсамбуу нарт хариуцуулсугай.

2. Хяналт шалгалтаар тогтоосон төлбөрийг хугацаанд нь барагдуулаагүй, илэрсэн зөрчлийг арилгаагүй тохиолдолд Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-д заасны дагуу хариуцлага хүлээлгэсүгэй.

3. Шинэжинст сумын Засаг даргын Тамгын газрын дарга Л.Батхуяг, Нягтлан бодогч Х.Доржсамбуу нар нь 19-06/..... тоот актыг 2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр хүлээн авсан бөгөөд 2,345,652 төгрөгийн төлбөрийг хугацаанд нь барагдуулаагүй, хохирлыг холбогдох этгээдээр төлүүлээгүй тохиолдолд Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас Баянхонгор аймгийн Шүүхэд хүсэлт, нэхэмжлэлийг гаргаж шийдвэрлүүлэхийг танилцуулсугай.

4. Та Монгол Улсын Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-т “Шалгуулсан байгууллага, аж ахуйн нэгжийн эрх баригч, албан тушаалтан хяналт шалгалтын явцад хууль тогтоомж зөрчигдсөн, гаргасан шийдвэр үндэслэлгүй гэж үзвэл гомдлоо хяналт шалгалт хийсэн байгууллагын эрх баригчид гаргана” гэсэн заалт, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 11.1-д заасны дагуу гомдол гаргахыг танилцуулсугай.

БИЧСЭН  
 САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН  
 АХЛАХ БАЙЦААГЧ Д.МӨНХХАНД  
 ТАНИЛЦАЖ ЗӨВШӨӨРСӨН.  
 БАЯНХОНГОР АЙМГИЙН ШИНЭЖИHNCT  
 СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
 ГАЗРЫН ДАРГА Л.БАТХУЯГ  
 РЕГИСТРИЙН ДУГААР: 42000 ВНЗД040116  
 ГЭРИЙН ХАЯГ  
 ОГНОО: 2024 ХУГАЦАА: 05.17  
 УТАС: 22709403  
 АЛБАНЫ ДАРГА Х.ДАГВАЖАВ  
 РЕГИСТРИЙН ДУГААР:  
 ГЭРИЙН ХАЯГ  
 ОГНОО: ХУГАЦАА:  
 УТАС:  
 БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТЫН  
 УЛСЫН БАЙЦААГЧ Ш.БЯМБАЦОГОО  
 РЕГИСТРИЙН ДУГААР: 110 ВС74072309  
 ГЭРИЙН ХАЯГ Төв ажил 5-500  
 ОГНОО: 2024.05.21 ХУГАЦАА:  
 УТАС: 99449766  
 ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ЖИЖИГ  
 ДУНД ҮЙЛДВЭР ХАРИУЦСАН  
 МЭРГЭЖИЛТЭН Г.ӨЛЗИЙБАТ  
 РЕГИСТРИЙН ДУГААР: ВС9310602  
 ГЭРИЙН ХАЯГ ШинэжиHNCT 4р баг  
 ОГНОО: 2024.06.17 ХУГАЦАА: 17:00  
 УТАС: 85589389  
 НЯГТЛАН БОДОГЧ Х.ДОРЖСАМБУУ  
 РЕГИСТРИЙН ДУГААР: ВС98032319  
 ГЭРИЙН ХАЯГ  
 ОГНОО: ХУГАЦАА:  
 УТАС: 88991054